НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2020 оны 10-р сар

Нийгмийн даатгалын санд 2020 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар нийт 1,201.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 130.4 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 630.2 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 2,015.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 372.6 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 10 сарын байдлаар 1,201.5 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 256.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 78.5% буюу 943.9 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 8.5% буюу 101.7 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 11.0% буюу 131.9 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 2.0% буюу 24.0 тэрбум төгрөг;

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2020 оны 10 сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд нийт 2,015.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 328.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН

10 сарын байдлаар тэтгэврийн даатгалын санд 943.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 369.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 441.2 мянган иргэдийн тэтгэвэрт 1,783.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 77.2 хувь буюу 1,376.0 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 334.9 мянган иргэнд зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

Энэ оны 10 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 164.1 мянган иргэнд 122.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн 92.8 тэрбум төгрөг буюу 75.8 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж эзэлж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН

Тус сангаас 10 сарын байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 7.0 мянган иргэнд 24.4 тэрбум төгрөгийг зарцуулав.

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

Ажилгүйдлийн даатгалын санд 10 сарын байдлаар 24.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 17.9 мянган хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 41.5 тэрбум төгрөгийг зарцуулсан. *Мөн цар тахал буюу коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын улмаас даатгуулагчид олгосон ажилгүйдлийн дэмжлэгт 44.1 тэрбум төгрөг олгосон.* Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.3 тэрбум төгрөгөөр буурч, зарлага 50.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГА

10 сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 182.9 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 92.0 хувь буюу 168.2 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж, байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 57.8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /сая төгрөгөөр/

	2019_10 сар	2020_10 сар	Зөрүү
Тахир дутуугийн	20,142.8	20,635.4	492.6
Тэжээгчээ алдсаны	2,268.2	2,437.6	169.4
Тэтгэмж. Төлбөрийн	1,477.3	794.2	-683.1
Сувиллын	671.1	469.6	-201.5
Нийт дүн	**24,559.4**	**24,336.8**	**-222.6**

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /сая төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 10 сарын байдлаар нийт 22,513.7 сая төгрөг төлөвлөснөөс 20,705.0 сая төгрөг зарцуулж, 1,808.8 сая төгрөг хэмнэсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6% буюу 1,460.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/

	2019_10 сар	2020_10 сар	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Цалингийн сан. нийгмийн даатгалын шимтгэл	15,243.1	16,897.9	1,654.8	10.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	4,001.7	3,807.1	194.6	-4.9%
Дүн	**19,244.8**	**20,705.0**	**1,460.2**	**7.6%**